



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 12

Дугаар 10/02


Баян-Өндөр сум

Аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн 2022 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 176,740,342.1 (нэг зуун далан зургаан тэрбум долоон зуун дөчин сая гурван зуун дөчин хоёр мянга нэг зуу) төгрөг, зарлагын гүйцэтгэлийг 168,123,398.5 (нэг зуун жаран найман тэрбум нэг зуун хорин гурван сая гурван зуун ерэн найман мянга таван зуу) төгрөг, төсвийн хэмнэлтийг 11,218,699.8 (арван нэгэн тэрбум хоёр зуун арван найман сая зургаан зуун ерэн есөн мянга найман зуу) төгрөг, давсан орлогыг 16,039,319.5 (арван зургаан тэрбум гучин есөн сая гурван зуун арван есөн мянга таван зуу) төгрөгөөр тус тус баталсугай.

2.Төсвийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д. МӨНХБАТ